



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 764

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 404,708.95 (дөрвөн зуун дөрвөн сая долоон зуун найман мянган) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэхэд дараах арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосугай.

2.1. Эрчим хүчний салбарын зарим төрийн өмчит компаниудад дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэх зөрчил дутагдал багагүй гарч байгаад анхаарч, зөрчил гаргасан албан тушаалтнуудад Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2.2 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 21.1.-д заасан “Төсвийн захирагч, энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан этгээдийн гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтан үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллаагүй нь тогтоогдсон бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно” гэж заасныг мөрдөж ажиллах,

3. “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн Гүйцэтгэх захирал (М.Түмэнжаргал)-д дотоод хяналтыг сайжруулан санхүүгийн сахилга батыг хэвшүүлж дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлж ажиллах;

3.2. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн

123006799
36-r_huraldaan.docx

хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах;

3.3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-нд заасны дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагааны тухайн жилийн цэвэр ашгаас төлөх төрийн өмчийн ногдол ашгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоосон хэмжээгээр дараа жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор төсөвт төвлөрүүлж байх;

3.4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

3.5.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 21.1.-д заасан “Төсвийн захирагч, энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан этгээдийн гүйцэтгэх удирдлага болон холбогдох албан тушаалтан үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллаагүй нь тогтоогдсон бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно” гэж заасныг мөрдөж ажиллах,

4.Тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 1-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт



ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ	
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээ	Захирал М.Түмэнжаргал Ерөнхий ня-бо Б.Роломжав	92,767.50	Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах,	
2	Дээд байгууллагын зардлыг хариуцсан	Захирал М.Түмэнжаргал Ерөнхий ня-бо Б.Роломжав	Сайд, Дэд сайд, ТНБД нарын шатахууны зардалд	41,836.20	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийг мөрдөж ажиллах
			Сайд, Дэд сайд, ТНБД нарын цайны зардалд	11,050.00	
			ЭХЯ-ны цахилгаан, дулааны техникийн хэсгийн ажлын хэсгийн зардалд	56,929.41	
			ЭХЯ-ны дотоод албан томилолтын зардалд	115,756.63	
			Гадаад томилолтын зардал	86,369.21	
			Дүн	311,941.45	
	Дүн		404,708.95 (дөрвөн зуун дөрвөн сая долоон зуун найман мянга)		